



## Жуулчин говь ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны тайлан

2020 онд дэлхийн нийтээр тархаад буй Ковид-19 цар тахалын улмаас компаниудын захиалга цуцлагдаж аялал жуулчлал зогсонги байдалтай өнгөрлөө.

2020 оны 5-р сарын 30-ны өдөр Жуулчин говь -1 бааз дээр гарч цэвэрлэгээ, үйлчилгээ, аж ахуйн бага зэрэг засвар үйлчилгээ хийлээ.

Тайлант жилд байнгын ажлын байрны 4 /Захирал, Нягтлан, манаач-2/ ажилтантай байлаа. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдсан боловч монгол амрагчдын сонирхол:

1. Аялалын маршрутын газрууддаа ойр байрлах Жуулчны баазад очих
2. Майханд хээрээр хоноглох зэргээс шалтгаалан бааз дээр буусангүй.

Жуулчинговь-1 бааз маань Ёлын ам, Баянзаг зэргээс аль альнаас хол байрладаг.

Жуулчинговь-2 бааз Хонгорын элсэнд байрладаг боловч Хонгорын элсэнд ажилладаг 1ч бааз үйл ажиллагаа явуулаагүй. Учир нь монгол аялагчид хээрээр, эсвэл гэр буудлуудаар бууцгаасан.

Тайлант онд ЖГ-1 бааз дотоодын 16 н аялагч л хүлээн авлаа. Нийт орлого 3,164,879.55т, нийт зардал 71,057,303.60. **ашиг, алдагдал -67,672,727.68**

1. Цалин хөлс	31,156,962.00т
2. НДШимтгэл төлөлт	1,661,559.24т
3. Хүнс	1,337,450.00т
4. Шатахууны зардал	698,843.41т
5. Шуудан холбоо, бичиг хэрэгт	1,017,244.84т
6. Ашиглалтын зардал	1,429,742.73т
7. Засварын зардал /машин/	225,000.00т
8. Аж ахуйн засвар	2,976,363.64т
9. Маркатөнгийн зардал	995,454.55т
10. Элэгдлийн зардал	20,415,525.70т
11. Албан татвар, төлбөр хураамж	5,765,100.00т
12. Зар сурталчилгаа	480,000.00т
13. Бусад зардал	2,898,057.49т

Оны эцэст ТТТранс ХХК-иас 5,300,000 төгрөг зээлж Жуулчинговь-1 бааз, Жуулчинговь-2 баазуудын газрын төлбөр 4,500,000т, Үл хөдлөх хөрөнгийн албан татварт 664,808т тус тус төлсөн.

Хонгорын голын бааз Тусгай хамгаалалттай бүсэд харъяалагддаг бөгөөд аймаг, сум орон нутаг, аж ахуйн нэгж 3-ын гурвалсан хамтран ажиллах гэрээг сунгах хүсэлтээ 2021 оны 03-р сарын 01-ны өдөр зохих газруудад материалаа бүрдүүлэн хүргүүлсэн болно.

Татвар, санхүү, НД зэрэг тайлангууд зохих журмын дагуу хугацаандаа илгээгдэн гайлагнагдаж байгаа болно.

Тайлан бичсэн нягтлан бодогч



Л.Мөнгөнцэцэг



## “ЖУУЛЧИН ГОВЬ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ТАЙЛАН

2021 оны 3 дугаар сар 12

Улаанбаатар хот

2020 онд ТУЗ 9 гишүүний бүрэлдхүүнтэй ажиллалаа. 2020 онд Дэлхийн нийтээр тархаад буй Ковид-19 цар тахалын улмаас баазын үйл ажиллагаа зогсонги байдалтай өнгөрлөө.

Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдсан боловч монгол аялагч амрагчдын сонирхол нь:

1. Үнэ өртөг хямд аялах
2. Аялах маршрутын ойр байрлаж майханд хоноглох зэрэг зүйлсүүдээс шалтгаалж бааз дээр буусангүй.

2020 оны жилийн эцсийн тайлангаар 3,164,879.73 төгрөг- /Гурван сая нэг зуун жаран дөрвөн мянга найман зуун далан есөн төгрөг далан гурван мөнгө/-ийн орлогтой, 71,057,303.60 /далан нэгэн сая тавин долоон мянга гурван зуун зурван төгрөг жаран мөнгө/ -ий зардалтай ажиллалаа. / Иийт зардлын 20,415,525.70 төгрөг нь Үл хөдлөх хөрөнгийн элэгдлийн зардал/

Тайлант онд 4 орон тоогоор л ажиллалаа. Захирал, нягтлан, 2 манаач.

Оны сүүлээр ТТТрансаас 5,300,000 төгрөгийн зээл авч Жуулчинговь-1, Жуулчинговь-2 баазын газрын төлбөр 4,500,000т, Үл хөдлөх хөрөнгийн албан татварт 664,808т төллөө. Тайлант онд бусад татварт 2,655,357.32т төлсөн

2021 онд аялал жуулчлалын үйл ажиллагаа мөн тодорхойгүй байна. Цаашид ажил жигдэртэл дахиад 1 жилийн хугацаа байх шиг байна.

Ямарч байсан санхүүгийн зохицуулах хороонаас гаргасан журмын дагуу ТУЗ-ийн ажлаа зохих журмын дагуу явуулж ажлын шаардлагын дагуу

-Компанийн дотоод хяналтын журам

- ТУЗ-ийн ажиллах журам

-Мэдээллийн үйл ажиллагааны журмуудыг сайжруулж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж мөрдүүлж ажиллана.

ТУЗ-ИЙН ДАРГА



Г. МӨНХБИЛЭГ

## Жуулчин Говь ХК хараат бус аудитийн дүгнэлт

Улаанбаатар хот

Жуулчин Говь ХК нь Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Мандах багийн нутагт байрладаг. Улирлын чанартай үйл ажиллагаагаа явуулдаг. 2020 оны 05 сарын 30 өдрөөс Жуулчин Говь 1 бааз дээр бэлтгэл ажиллагаа хийж эхэлсэн боловч цар тахалтай онцгой байдлаас шалтгаалан 16 монгол аялагч хүлээн авчээ.

Тайлант жилд 3,164,879.55 төгрөгийн орлого олжээ.

### Нийт зардал

НДШ	1,661,559.24
Хүнс	1,337,450.00
Шатхуун	698,843.41
Шуудан бичиг хэрэг	1,017,244.84
Цалин	31,156,962.00
Ашиглалт зардал	1,429,742.73
Засварын зардал	225,000.00
Аж ахуйн засварасвар	2,976,363.64
Марктенг зардал	995,454.55
Элэгдэл зардал	20,415,525.70
Зар сурталчилгаа	480,000.00
Бусад зардал	2,898,057.49
Татвар зардал	5,765,100.00
Бүгд	<b>71,057,303.60</b>
алдагдал	<b>(67,672,727.68)</b>

2020 онд үндсэн 4 ажилтан захирал ня-бо 2 манаач ажиллажээ.

ТТТрансаас зээл авч	<b>5,300,000.00</b>
Газрын төлбөрт	4,500,000.00
Үл хөдлөхийн татвар	664,808.00
<b>Дүн</b>	<b>5,164,808.00</b> тус тус төлжээ.

Санхүүгийн тайлан. Татварын .НДаатгалын тайланг зохих журмын дагуу цаг хугацаанд нь гаргажээ.

2020 онд ХАОАТ	415,750.07
Цалингийн өглөг	5,645,419.43
Өглөг	<b>6,061,169.50</b>

2021 онд үйл ажиллагаа явуулахад эргэлтийн хөрөнгө зайлшгүй шаардлагатай байна.

Тайлан бичсэн



Будханд

2021 оны 03 сарын 12 өдөр